

**2023 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

Үүргийн биелэлтийг Агаар-12 фонтоор бичиж, 2023 оны 09 дүгээр сарын 8, 11-ний өдрүүдэд багтаан e-doc системээр албан бичгээр ирүүлж, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (ERP Б.Одбаяр)-т файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцно.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭХ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД		
1	2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг сайтар хангаж, өвлийн их ачааллын үед иргэдийг ус, дулаан, цахилгаан эрчим хүчээр найдвартай хангахад онцгой анхаарах, инженер хангамжийн байгууллагууд болон нийт байгууллагууд 09 дүгээр сарын 15-ны дотор төлөвлөсөн ажлуудаа бүрэн дуусгах.	ТХҮХ, инженерийн дэд бүтцийн байгууллагууд, ААНБ
ЦАГ ҮЕИЙН АСУУДЛЫН ХҮРЭЭНД		
2	Дүүргийн хэмжээнд үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн болон боловсролын байгууллагын гадна орчны тохижилт, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг эрчимжүүлж, хяналт тавьж ажиллах.	Боловсролын хэлтэс, ЭМТ
3	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилт, цэвэрлэгээг тогтмолжуулах, явган хүний зам, гадна хаяг, рекламны самбар, бүрэн бүтэн байдал алдагдсан, эрсдэл үүссэн хүүхдийн тоглоомын талбайг засварлах, аюулгүй байдлыг хангуулж стандартад нийцүүлж ажлыг эрчимжүүлэх.	ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
4	Хүүхэд залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, биеийн тамир спортоор хичээллэх нөхцөл боломжийг бүрдүүлэх ажлын хүрээнд 3*3 сагсан бөмбөгийн талбай байгуулах болон бусад тохижилтын ажлуудыг эрчимжүүлж ажиллах. (3*3 сагсан бөмбөгийн талбай, бичил цэцэрлэгт хүрээлэн)	ТХҮХ
5	Хүүхдийн тоглоомын талбай, Сагсан бөмбөгийн талбай болон цэцэрлэгт хүрээлэнгийн орчимд 22:00 цагаас хойш хүүхэд багачууд тоглож, иргэд, оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөн туслах ажлыг зохион байгуулах.	Цагдаагийн хэлтэс, холбогдох ААНБ-ууд
6	Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулагдаж, иргэд, ААНБ-уудаас санал авч байгаатай уялдуулан холбогдох саналыг нэгтгэн хугацаандаа хүргүүлэх.	ТХҮХ
ТӨСВИЙН ОРЛОГО БҮРДҮҮЛЭХ БОЛОН БУСАД АЖЛЫН ХҮРЭЭНД		
7	Орлого төвлөрүүлэгч байгууллагууд орлогын тасалдлыг нөхөж, төсвийн орлогын гүйцэтгэлийг хангах ажлаа эрчимжүүлж ажиллах.	СТСХ, Татварын хэлтэс
8	Нийслэл дэх Төрийн аудитын байгууллагын аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг сайтар хангуулж, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналттай холбоотой холбогдох хууль тогтоомж, заавар журмыг мөрдөн, төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй анхаарч ажиллах.	ЗДО Б.Болормаа СТСХ, ДАА, ААНБ-ууд
9	Нийслэлийн Засаг даргын ажлын хэсэг байгуулсан захирамжуудын хэрэгжилтийг эрчимжүүлж, хяналт тавьж ажиллах.	ЗДТГ-ын дарга Л.Санжийжамц
10	Албан хаагчдын хариуцлагыг сайжруулж, тайлан мэдээний чанарт ахиц гаргах, хэрэгжилтийг үнэн, зөв, шуурхай тайлагнаж, бодит мэдээллээр хангаж ажиллах.	ААНБ-ууд
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
11	1 дүгээр хорооны СӨХ-ны цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах, 2 дугаар хорооны СӨХ-ны хурлын товыг тогтоон, зарлах.	ТХҮХ

12	2023-2024 оны хичээлийн жилийн багш нарын “Бага хурал”-ыг зохион байгуулах товыг тогтоох, бэлтгэлийг сайтар хангах.	ЗДО Б.Болормаа НХХ, Боловсролын хэлтэс
13	<p>Дараах мэдээллүүдийг 2020-2023 оны байдлаар нэгтгэж, графикаар харьцуулан 2023.09.07 (Пүрэв)-ны өдрийн 10:00 цагт багтаан танилцуулах. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Хөрөнгө оруулалтын ажлуудын мэдээлэл (улс, нийслэл, дүүрэг, ОНХС)-ХААА 2. Боловсролын салбарын статистик мэдээ, хэрэгцээ шаардлага-Боловсролын хэлтэс 3. Гэрэлтүүлэг, ногоон байгууламж, камер, модны тоо, цаашдын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох (Багахангай сүү, Төмөр замын байгууллага зэрэг хувийн хэвшлийн тарьж ургуулсан мод мөн хамаарах)-Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ 4. Нийт замын хэмжээ, явган замын хэмжээ, тоглоомын талбай болон засаж сайжруулах шаардлагатай, цаашид нэмэх шаардлагатай замын хэмжээг тодорхойлох-ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ 5. Газар олголтын мэдээлэл (үйлдвэр үйлчилгээ, ААНБ-ын тусгай хэрэгцээ, өрхийн хэрэгцээ)-ГЗБА 6. Татварын орлого бүрдүүлэлтийн мэдээлэл (улс, нийслэл, дүүрэг)-Татварын хэлтэс 7. Дүүргийн хэмжээний өргөдөл, гомдол, ирсэн явсан бичгийн тоо, шийдвэрлэлтийн хугацаа-ТЗУХ 8. Малын тоо-ХААТ (Статистик) 9. Гэмт хэрэг, зөрчлийн тоо-Цагдаагийн хэлтэс 10. Эрчим хүчний нөхцөл байдал, хэрэгцээ шаардлага-ТХҮХ (эчвод, эрчим хүч) 11. Дулааны хүчин чадал, хэрэгцээ шаардлага-ТХҮХ, Илч-орд ОНӨААТҮГ, БОС 12. Ажилгүйдлын тоо, зарлагдсан ажлын байрны тоо, ажлын байранд зуучилсан иргэдийн тоо, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх хүрээнд хэрэгжүүлсэн хөтөлбөр болон санхүүжилтийн хэмжээ-ХХҮХ 13. Эрүүл мэндийн чиглэлийн статистик мэдээлэл (урьдчилан сэргийлэх үзлэг)-ЭМТ 	